



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот


“Улаанбаатарын өвлийн наадам” арга  
хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/82 дугаар захирамж, нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар баталсан газрын дүрмийн 7.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах, өвлийн улиралд Улаанбаатар хотод ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Улаанбаатарын өвлийн наадам” арга хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Наадмыг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталж, шаардагдах 110,959,800 /нэг зуун арван сая есөн зуун тавин есөн мянга найман зуун/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч /Д.Уянга/-д зөвшөөрсүгэй.

3.Арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс /С.Туул/-т даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2024 оны 01 сарын 22 өдрийн  
... дугаар тушаалын хавсралт



**“УЛААНБААТАРЫН ӨВЛИЙН НААДАМ” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА**

2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
<b>Талбайн тохижилтын зардал</b>				
1	Мөсөн хананы талбай бэлтгэх	Багц	10,000,000	10,000,000
2	Арга хэмжээний тайз засал, хөгжим техникийн түрээс /3ш тайз/	Багц	25,000,000	25,000,000
3	Арга хэмжээний цахилгаан, ус, хогны зардал	Багц	2,000,000	2,000,000
4	Тугны суурь түрээс	20 ш*2 өдөр	50,000	2,000,000
<b>Дүн</b>				<b>39,000,000</b>
<b>Зохион байгуулалтын арга хэмжээ</b>				
5	Рагбигийн ХАШТ-ний зохион байгуулалтын зардал	Багц	3,000,000	3,000,000
6	Параглайдингийн ХАШТ-ний шагнал, үзүүлбэрийн зардал	Багц	2,395,000	2,395,000
7	Мөсөн хананд авиралтын тэмцээний зохион байгуулалтын зардал	Багц	2,000,000	2,000,000
8	Гэр бүлийн буухиа, олс таталтын тэмцээний зохион байгуулалтын зардал	6 шүүгч*2 өдөр	80 000	960,000
9	Нохой чарганы тээвэрлэлтийн хөлс	4 удаа	300,000	1,200,000
10	Шувуулахуйн биет бус уламжлалт өв соёл болон махчин шувуудын танин мэдэхүйн хөтөлбөр	Багц	2,000,000	2,000,000
11	Хөтлөгчийн зардал	1 хүн *2 өдөр	1,500,000	3,000,000
12	Гэр түрээслэх	5ш *2 өдөр	400,000	4,000,000
13	Ачааны машин түрээслэх	2 удаа	500,000	1,000,000
14	Залуучуудад зориулсан шоу тоглолт	Багц	15,000,000	15,000,000
15	Цагдаагийн хашлага үйлчилгээ, тээвэрлэлт	Багц	500,000	500,000
16	Зураг авхуулах орчин бүрдүүлэх	Багц	2,000,000	2,000,000



17	Зохион байгуулагчдын хоолны зардал	50 хүн /2 өдөр/	10,000	1,000,000
18	Гадаад тамирчдын хоолны зардал	60 хүн/2 өдөр*2 удаа	25,000	6,000,000
19	Гадаад зочид, тамирчдын зочид буудлын зардал	6 өрөө *3 өдөр	200,000	3,600,000
20	360 эргэдэг тавцан түрээс	1ш*2 өдөр	1,000,000	2,000,000
21	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	1ш*3 өдөр	400,000	1,200,000
<b>Дүн</b>				<b>50,855,000</b>
<b>Сурталчилгаа, маркетингийн зардал</b>				
22	Шторк геел бэлтгэх	Багц	5,000,000	5,000,000
23	Сурталчилгааны материал /постер, анонс, хөтөлбөр/ эх бэлтгэл, хэвлэлт	Багц	5,000,000	5,000,000
24	Шууд дамжуулалт	Багц	10,500,000	10,500,000
25	Сити тур автобусны түлшний зардал	1ш *6 удаа жолооч	240км*420 0	604,800
<b>Дүн</b>				<b>21,104,800</b>
<b>Нийт дүн</b>				<b>110,959,800</b>

--- оОо ---